



ВАКЦИНЫ ТАНИЛЦУУЛГА



БИОКОМБИНАТ ТӨХХК

Биокомбинат нь төрийн өмчит хариуцлагатай хувьцаат компани бөгөөд мал эмнэлгийн зориулалт бүхий вакцин, оношлуур зэрэг биобэлдмэл үйлдвэрлэдэг биотехнологийн үндэсний ууган үйлдвэр юм.

ЗОРИЛГО

Технологийн шинэчлэлт, өндөр чанар, эрүүл мал

ЗОРИЛТ

Шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлийн нэг болох биотехнологийн зарчимд тулгуурлан орчин үеийн шаардлагад нийцүүлэн брилга байгууламж, дэвшилтэт технологи, мэргэжлийн чадварлаг хамт олны бүрэлдэхүүнтэйгээр өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, Монгол улсын мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд тодорхой хувь нэмрээ оруулах.



ТҮҮХИЙН ХУУДАС



1923 он

«Үхрийн мялзанг эсэргүүцэх станц» нэртэйгээр Биокомбинат ТӨААТҮГ-ын суурь тавигдсан.

1973 он

БНУУ-ын техник, эдийн засгийн тусламжтайгаар бүрэн шинэчлэгдсэн.

2024 он

Дараах 2 төслийг амжилттай хэрэгжүүлж үйлдвэрлэлд нэвтрүүлэв.

1. Дэлхийн банкны LCP төслийн санхүүжилт, дэмжлэгээр "Шугаман эсийн төсөл" хэрэгжүүлэлт 210 м² Үйлдвэрлэлийн байрыг GMP шаардлагад нийцүүлэн засварлаж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн иж бүрэн шинэчлэл хийж, мэргэжилтнүүдийг шугаман эсийн технологит сургав.
2. Компанийн өөрийн хөрөнгө оруулалтаар "Автомат савлагааны төсөл" хэрэгжүүлж 700 м² үйлдвэрлэлийн байрыг GMP шаардлагад нийцүүлэн засварлаж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг иж бүрэн шинэчиллээ.



БИОКОМБИНАТ ТӨХХК

Нийт 230 гаруй ажилтан, мэргэжилтнүүдээс бүрдсэн 4 алба, 17 цех, нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Жилдээ 50 сая орчим тун биобэлдмэл үйлдвэрлэдэг.

Нийт 40 гаруй нэр төрлийн биобэлдмэл үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээг 100% импорт орлох бүтээгдэхүүнээр хангаж байна.

Манай бүтээгдэхүүн нь Монгол орны бүх аймаг, сум, багт хүрч хэрэглэгддэг.



ГАРЧИГ

- 01 ШУВУУГ МАРЕК ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ rMDV-MS-Δmeq ОМГИЙН АМЬД ВАКЦИН
- 02 ШУВУУГ МАРЕК ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ FC-126 ОМГИЙН АМЬД ВАКЦИН
- 03 ШУВУУГ ТАХАЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ LA SOTA ОМГИЙН АМЬД ВАКЦИН
- 04 ШУВУУГ ТАХАЛ, ХАЛДВАРТ БРОНХИТ, ӨНДӨГЛӨЛТ БУУРАХ ХАМ ШИНЖ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН
- 05 ШУВУУГ ТАХАЛ, ХАЛДВАРТ БРОНХИТ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ АМЬД ХАМ ВАКЦИН (La Sota омог + H52 омог)
- 06 ШУВУУГ ТАХАЛ, ХАЛДВАРТ БРОНХИТ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ АМЬД ХАМ ВАКЦИН (La Sota омог + H120 омог)
- 07 ХАЛДВАРТ БУРСАЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ NF8 ОМГИЙН АМЬД ВАКЦИН
- 08 ШУВУУГ ТАХАЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ Clone V4/HB92 ОМГИЙН АМЬД ВАКЦИН
- 09 ШУВУУГ ЦЭЦЭГ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ АМЬД ВАКЦИН
- 10 ШУВУУГ ТАХАЛ, ХАЛДВАРТ БРОНХИТ, ШУВУУНЫ ХАНИАДААС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН (La Sota омог + M41 омог + HP омог)
- 11 ШУВУУГ ТАХАЛ, ХАЛДВАРТ БРОНХИТ, ШУВУУНЫ ХАНИАД, ХАЛДВАРТ БУРСАЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН (La Sota омог + M41 омог + SZ омог + rVP2 уураг)
- 12 ШУВУУГ ТАХАЛ, ШУВУУНЫ ХАНИАДААС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ХАМ ВАКЦИН (La Sota омог + F омог)
- 13 ШУВУУГ ТАХАЛ, ХАЛДВАРТ БРОНХИТ, ӨНДӨГЛӨЛТ БУУРАХ ХАМ ШИНЖ, ШУВУУНЫ ХАНИАДААС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ХАМ ВАКЦИН (La Sota омог + M41 омог + AV127 омог + NJO2)

ШУВУУГ МАРЕК ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ rMDV-MS-Δmeq ОМГИЙН АМЬД ВАКЦИН

01 **Олон улсын нэр:** Marek's disease vaccine, Live (Strain rMDV-MS-Δmeq)

02 **Тодорхойлолт:** Марек өвчнөөс сэргийлэх амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч *Herpesviridae* язгуурын *Herpesvirus* төрөлд хамаарах вирусын хоруу чанарыг сулруулсан, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй rMDV-MS-Δmeq омгийг SPF-тахиааны үр хөврөлт өндөгний амнион-аллантайс бүрхүүлд өсгөвөрлөж, тусгай найрлага бүхий тогтворжуулан-хамгаалах орчинтой зохих харьцаагаар хольж, лиофилизацийн аргаар хуурайшуулан бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.

03 **Найрлага:** Марек өвчнөөс сэргийлэх амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч вирусын rMDV-MS-Δmeq омгийн эсрэгтөрөгч агуулна. Вирусын таньц 1 тунд ≥ 2000 PFU байна.

07 **Гадаад байдал, хэлбэр:** Цайвар шаргал, цайвар улаан өнгийн хуурай нунтаг

05 **Зориулалт:** Марек өвчнийг үүсгэгч вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай

06 **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Өндөглөгч шувууны аж ахуйн 1 хоногийн настай дэгдээхийг вакцинжуулна.

07 **Олгох зам:** Хүзүүний арын хэсгийн арьсан дор тарьж олгоно.

08 **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцинжуулснаас 7 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэж насан туршийн дархлаа тогтооно.

09 **Шингэлэх арга:** Вакцины 1 тунг 0,2 мл зориулалтын шингэлэгч уусмалаар шингэлнэ.

10 **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.

11 **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй

12 **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Шингэн азоттой зориулалтын саванд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэснээс хойш 24 сар хүртэл хүчинтэй.

13 **Бүртгэлийн дугаар:** QF-1346

14 **Үйлдвэрлэгч:** Liaoning Yikang Biological Corporation Limited



ШУВУУГ МАРЕК ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ FC-126 ОМГИЙН АМЬД ВАКЦИН

01 Олон улсын нэр: Marek's disease vaccine, Live (Strain FC-126)

02 Тодорхойлолт: Шувууг тахал өвчнөөс сэргийлэх амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч *Herpesviridae* язгуурын *Herpesvirus* төрөлд хамаарах вирусын хоруу чанарыг сулруулсан, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй FC-126 омгийг SPF-тахианы үр хөврөлт өндөгний амнион-аллантайс бүрхүүлд өсгөвөрлөж, тусгай найрлага бүхий тогтворжуулан-хамгаалах орчинтой зохих харьцаагаар хольж, лиофилизацийн аргаар хуурайшуулан бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.

03 Найрлага: Марек өвчнөөс сэргийлэх амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч вирусын FC-126 омгийн эсрэгтөрөгч агуулна. Вирусын таньц 1 тунд ≥ 2000 PFU байна.

04 Гадаад байдал, хэлбэр: Цайвар шаргал, шаргал өнгийн хуурай нунтаг

05 Зориулалт: Марек өвчний үүсгэгч вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай

06 Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс: Махны чиглэлийн тахианы аж ахуйн 1 хоногийн настай дэгдээхийг вакцинжуулна.

07 Олгох зам: Хүзүүний арын хэсгийн арьсан дор, эсвэл булчинд тарьж олгоно.

08 Дархлааны үргэлжлэх хугацаа: Вакцинжуулснаас 7 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэж насан туршийн дархлаа тогтооно.

09 Шингэлэх арга: Вакцины 1 тунг 0,2 мл зориулалтын шингэлэгч уусмалаар шингэлнэ.

10 Аюулгүй чанар: Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.

11 Гаж нөлөө: Тэмдэглэгдээгүй

12 Хадгалалт, хүчинтэй хугацаа: Вакциныг -15°C -ээс нам температурт харанхуй байранд хадгалвал үйлдвэрлэсэн өдрөөс хойш 18 сар хүртэл хүчинтэй.

13 Бүртгэлийн дугаар: QF-1347

13 Үйлдвэрлэгч: Liaoning Yikang Biological Corporation Limited



ШУВУУГ ТАХАЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ LA SOTA ОМГИЙН АМЬД ВАКЦИН

01 Олон улсын нэр: Newcastle disease vaccine, Live (Strain La sota)

02 Тодорхойлолт: Шувууг тахал өвчнөөс сэргийлэх амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч *Orthomyxoviridae* язгуурын *Influenzavirus* төрөлд хамаарах РНХ агуулсан вирусын хоруу чанарыг нь сулруулсан, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгийг тахианы үр хөврөлт өндөгний амнион-аллонтойс бүрхүүлд өсгөвөрлөж, тусгай найрлага бүхий тогтворжуулан-хамгаалах орчинтой зохих харьцаагаар хольж, лиофилизацийн аргаар хуурайшуулан бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.

03 Найрлага: Тахал өвчнөөс сэргийлэх амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч вирусын хоруу чанарыг нь сулруулсан *La Sota* омгийн эсрэгтөрөгч, хамгаалан-тогтворжуулагч орчин агуулна.

04 Гадаад байдал, хэлбэр: Цайвар шаргал болон ягаавтар туяатай цайвар өнгийн хуурай нунтаг

05 Зориулалт: Тахал өвчнийг үүсгэгч вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай .

06 Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс: Шувууг нас, хүйс харгалзахгүйгээр вакцинжуулна. Шувууны аж ахуйн шувууг эхлээд 3 удаа вакцинжуулах ба цаашдаа 4 сар тутамд тогтмол вакцинжуулна. Үүний тулд 10-14 хоногийн настай дэгдээхийд анхдагч тунг, 60 хоногийн настай нь хоёрдогч тунг, 4-5 сарын настайд нь гуравдагч тунг олгоод улмаар 4 сар тутамд вакцинжуулна.

Амьтны төрөл	Олгох зам	Тун
Шувуу	Хамар, нүдэнд дусаах	1 тун буюу 0,05 мл
	Амаар олгох, шүрших	2 тун буюу 0,1 мл

07 Олгох зам: Хамар, нүдэнд дусаах, ундны усанд уусгаж амаар, эсвэл шүршиж олгоно.

08 Дархлааны үргэлжлэх хугацаа: Вакцинжуулснаас 10-14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь шувууг 4 сарын турш уг халдварт өвчнөөс найдвартай сэргийлнэ.

09 Шингэлэх арга: Энэхүү вакциныг хамар, нүдэнд дусааж олгох тохиолдолд 1 тунг 0,05 мл 0,9%-ийн натрийн хлорид (физиологийн уусмал)-ын уусмалд, амаар олгох, эсвэл шүршиж олгох тохиолдолд 2 тунг 0,1 мл ундны усанд уусгаж шингэлнэ.

10 Аюулгүй чанар: Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.

11 Гаж нөлөө: Тэмдэглэгдээгүй.

12 Хадгалалт, хүчинтэй хугацаа: Вакциныг -15°C-ээс нам харанхуй хуурай нөхцөлд хадгалвал үйлдвэрлэсэн өдрөөс хойш 24 сар хүртэл хүчинтэй.

13 Бүртгэлийн дугаар: QF-1356

08 Үйлдвэрлэгч: Sinopharm Yangzhou Vac Biological Engineering Co., Ltd



ШУВУУГ ТАХАЛ, ХАЛДВАРТ БРОНХИТ, ӨНДӨГЛӨЛТ БУУРАХ ХАМ ШИНЖ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН

01 Олон улсын нэр: Newcastle disease, Infectious bronchitis and Egg drop syndrome 76 vaccine, Inactivated

02 Тодорхойлолт: Шувууг тахал, халдварт бронхит, өндөглөлт буурах хам шинж өвчнөөс сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин нь эдгээр халдварт өвчний үүсгэгч вирусын дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудыг тахианы үр хөврөлт өндөгний амнион-аллонтаис бүрхүүлд өсгөвөрлөж, формальдегидаар идэвхгүйжүүлэн тосон адьюванттай тодорхой харьцаагаар хольж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.

03 Найрлага: Энэхүү вакцин нь тахал өвчний үүсгэгчийн La Sota омгийн эсрэгтөрөгч, халдварт бронхит үүсгэгчийн M41 омгийн эсрэгтөрөгч, өндөглөлт буурах хам шинж өвчний үүсгэгч вирусын Z16 омгийн эсрэгтөрөгч болон тосон адьювант, идэвхгүйжүүлэгч зэргийг агуулна.

04 Гадаад байдал, хэлбэр: Сүүн цагаан өнгөтэй шингэн

05 Зориулалт: Шувууг тахал, халдварт бронхит, өндөглөлт буурах хам шинж өвчнийг үүсгэгч вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.

06 Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс: Өндөглөгч тахиаг өндөглөж эхлэхээс 1 сарын өмнө 0,5 мл тунгаар вакцинжуулна.

07 Олгох зам: Өндөглөгч тахианы сүвний арьсан дор, эсвэл булчинд тарьж хэрэглэнэ.

08 Дархлааны үргэлжлэх хугацаа: Вакцины зохистой тунг олгосноос 7-14 хоногийн дараа вакцинжуулсан амьтдын бие махбодид идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь 6 сарын турш тогтвортой хадгалагдана.


09 Аюулгүй чанар: Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.

10 Гаж нөлөө: Тэмдэглэгдээгүй.

11 Хадгалалт, хүчинтэй хугацаа: Вакциныг +2°C-аас +8°C-ийн харанхуй, хуурай нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүртэл хүчинтэй.

12 Бүртгэлийн дугаар: QF-1354

13 Үйлдвэрлэгч: Sinopharm Yangzhou Vac Biological Engineering Co., Ltd



ШУВУУГ ТАХАЛ, ХАЛДВАРТ БРОНХИТ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ АМЬД ХАМ ВАКЦИН (La Sota омог + H52 омог)

- 01** **Олон улсын нэр:** Combined Newcastle disease and Infectious bronchitis vaccine, Live (Strain La sota + Strain H52)
- 02** **Тодорхойлолт:** Шувууг тахал, халдварт бронхит өвчнөөс сэргийлэх амьд хам вакцин нь эдгээр халдварт өвчнийг үүсгэгч вирусын хоруу чанарыг нь сулруулсан, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудыг тахианы үр хөврөлт өндөгний амнион-аллонтойс бүрхүүлд өсгөвөрлөж, тусгай найрлага бүхий тогтворжуулан-хамгаалах орчинтой зохих харьцаагаар хольж, лиофилизацийн аргаар хуурайшуулан бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- 03** **Найрлага:** Энэхүү амьд хам вакцин нь тахал өвчнийг үүсгэгч вирусын хоруу чанарыг нь сулруулсан La Sota буюу H52 омгийн эсрэгтөрөгч, халдварт бронхит өвчнийг үүсгэгч вирусын H52 омгийн эсрэгтөрөгч, хамгаалан-тогтворжуулагч орчингоос бүрдэнэ.
- 04** **Гадаад байдал, хэлбэр:** Цайвар, цайвар шаргал өнгийн сэвсгэр хуурай нунтаг
- 05** **Зориулалт:** Вакцин нь тахал, халдварт бронхит өвчнийг үүсгэгч вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай .
- 06** **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** 21 хоногоос дээш настай дэгдээхийг вакцинжуулна.

Нас	Олгох зам	Тун
20-30 хоногийн настай	Хамарт дусаах	1 тун буюу 0,03 мл
	Амаар олгох	10-20 мл
30 хоногоос дээш настай	Хамарт дусаах	1 тун буюу 0,03 мл
	Амаар олгох	20-30 мл

- 07** **Олгох зам:** Хамарт дусаах, ундны усанд уусгаж амаар олгоно.
- 08** **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцинжуулснаас 10-14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь шувууг 4 сарын турш тахал болон халдварт бронхит өвчнөөс бүрэн сэргийлнэ.
- 09** **Шингэлэх арга:** Вакциныг хамар, нүдэнд дусааж олгох тохиолдолд 1 тунг 0,03 мл 0,9%-ийн натрийн хлорид (физиологийн уусмал)-ын уусмалд, амаар олгох тохиолдолд 1 тунг 10-20 мл ундны усанд уусгаж шингэлнэ.
- 10** **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.
- 11** **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- 12** **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Вакциныг -15°C-ийн харанхуй хуурай нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 18 сар хүртэл хүчинтэй.
- 13** **Бүртгэлийн дугаар:** QF-1353
- 14** **Үйлдвэрлэгч:** Sinopharm Yangzhou Vac Biological Engineering Co., Ltd



ШУВУУГ ТАХАЛ, ХАЛДВАРТ БРОНХИТ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ АМЬД ХАМ ВАКЦИН (La Sota омог + H120 омог)

01 **Олон улсын нэр:** Combined Newcastle disease and Infectious bronchitis vaccine, Live (Strain La sota + Strain H120)

02 **Тодорхойлолт:** Шувууг тахал, халдварт бронхит өвчнөөс сэргийлэх амьд хам вакцин нь эдгээр халдварт өвчнийг үүсгэгч вирусын хоруу чанарыг нь сулруулсан, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудыг тахианы үр хөврөлт өндөгний амнион-аллантай бүрхүүлд өсгөвөрлөж, тусгай найрлага бүхий тогтворжуулан-хамгаалах орчинтой зохих харьцаагаар хольж, лиофилизацийн аргаар хуурайшуулан бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.

03 **Найрлага:** Энэхүү вакцин нь тахал өвчнийг үүсгэгч вирусын хоруу чанарыг нь сулруулсан La Sota омгийн эсрэгтөрөгч, халдварт бронхит өвчнийг үүсгэгч вирусын H120 омгийн эсрэгтөрөгч, хамгаалан-тогтворжуулагч орчин агуулна.

04 **Гадаад байдал, хэлбэр:** Цайвар, цайвар шаргал өнгийн хуурай нунтаг

05 **Зориулалт:** Тахал болон халдварт бронхит өвчнийг үүсгэгч вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай .

06 **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** 7 хоногоос дээш настай шувууг вакцинжуулна.

Нас	Олгох зам	Тун
5-10 хоногийн настай	Хамарт дусаах	1 тун буюу 0,03 мл
	Амаар олгох	5-10 мл
20-30 хоногийн настай	Хамарт дусаах	1 тун буюу 0,03 мл
	Амаар олгох	10-20 мл
30 хоногоос дээш настай	Хамарт дусаах	1 тун буюу 0,03 мл
	Амаар олгох	20-30 мл

07 **Олгох зам:** Хамарт дусаах, ундны усанд уусгаж амаар олгоно.

08 **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцины зохистой тунг олгосноо 10-14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь 4 сарын турш тахал болон халдварт бронхит өвчнөөс найдвартай хамгаална.

09 **Шингэлэх арга:** Вакциныг хамар, нүдэнд дусааж олгох тохиолдолд 1 тунг 0,03 мл 0,9%-ийн натрийн хлорид (физиологийн уусмал)-ын уусмалд, амаар олгох олгох тохиолдолд 1 тунг 10-20 мл ундны усанд уусгаж шингэлнэ.

10 **Шингэлэх арга:** Вакциныг хамар, нүдэнд дусааж олгох тохиолдолд 1 тунг 0,03 мл 0,9%-ийн натрийн хлорид (физиологийн уусмал)-ын уусмалд, амаар олгох олгох тохиолдолд 1 тунг 10-20 мл ундны усанд уусгаж шингэлнэ.


11 **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.

12 **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй

13 **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Вакциныг -15°C-ийн харанхуй, хуурай байранд хадгалвал үйлдвэрлэсэн өдрөөс хойш 18 сар хүртэл хүчинтэй.

14 **Бүртгэлийн дугаар:** QF-1352

15 **Үйлдвэрлэгч:** Sinopharm Yangzhou Vac Biological Engineering Co., Ltd



ХАЛДВАРТ БУРСАЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ NF8 ОМГИЙН АМЬД ВАКЦИН

01 **Олон улсын нэр:** Infectious bursal disease vaccine, Live (Strain NF8)

02 **Тодорхойлолт:** Шувууг халдварт бурсал (Гамборо) өвчнөөс сэргийлэх NF8 омгийн амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч *Birnaviridae* язгуурын *Avibirnavirus* төрөлд хамаарах РНХ агуулсан вирусын хоруу чанарыг нь сулруулсан, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй NF8 омгийг тахианы үр хөврөлт өндөгний амнион-аллонтойс бүрхүүлд өсгөвөрлөж, тусгай найрлага бүхий тогтворжуулан-хамгаалах орчинтой зохих харьцаагаар хольж, лиофилизацийн аргаар хуурайшуулан бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.

03 **Найрлага:** Халдварт бурсал өвчнөөс сэргийлэх амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч вирусын хоруу чанарыг нь сулруулсан NF8 омгийн эсрэгтөрөгч, хамгаалан-тогтворжуулагч орчин агуулна.

04 **Гадаад байдал, хэлбэр:** Цайвар, цайвар шаргал өнгийн хуурай нунтаг

05 **Зориулалт:** Халдварт бурсал өвчнийг үүсгэгч вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.

06 **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** 10 хоногоос дээш настай дэгдээхийг вакцинжуулна. Эх тахианы цусан дах эсрэгбиеийн таньц тодорхой бус тохиолдолд 10-14 хоногийн настай дэгдээхийд эхний тунг олгоод 2 дах тунг 7-14 хоногийн дараа олгоно. Харин эх тахианы эсрэгбиеийн таньц өндөр тохиолдолд дэгдээхийг 18-21 хоногийн настайд эхний тунг олгоод 7-14 хоногийн дараа 2 дах тунг олгоно.

07 **Олгох зам:** Нүдэнд дусаах, тарих, эсвэл ундны усанд уусгаж амаар олгоно.

08 **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Шувуунд бурсал өвчнөөс сэргийлэх вакцины хоёрдох тунг олгосноос 10-14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь шувууг 6 сарын турш халдварт бурсал өвчнөөс найдвартай сэргийлнэ.

09 **Шингэлэх арга:** Вакциныг шошгонд заасны дагуу 0,9%-ийн натрийн хлорид (физиологийн уусмал)-ын уусмал болон ундны усанд уусгаж шингэлнэ.

10 **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.

11 **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй

12 **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү амьд вакциныг -15°C-ийн харанхуй хуурай нөхцөлд хадгалвал үйлдвэрлэсэн өдрөөс хойш 18 сар хүртэл хүчинтэй.

13 **Бүртгэлийн дугаар:** QF-1355

14 **Үйлдвэрлэгч:** Sinopharm Yangzhou Vac Biological Engineering Co., Ltd



ШУВУУГ ТАХАЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ Clone V4/НВ92 ОМГИЙН АМЬД ВАКЦИН

08 Олон улсын нэр: Newcastle disease vaccine, Live (Strain Clone V4/НВ92)

02 Тодорхойлолт: Шувууг тахал өвчнөөс сэргийлэх амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч *Orthomyxoviridae* язгуурын *Influenzavirus* төрөлд хамаарах РНХ агуулсан вирусын хоруу чанарыг нь сулруулсан, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй Clone V4/НВ92 омгийг тахианы үр хөврөлт өндөгний амнион-аллантай бүрхүүлд өсгөвөрлөж, тусгай найрлага бүхий тогтворжуулан-хамгаалах орчинтой зохих харьцаагаар хольж, лиофилизацийн аргаар хуурайшуулан бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.

03 Найрлага: Тахал өвчнөөс сэргийлэх амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч вирусын хоруу чанарыг нь сулруулсан Clone V4/НВ92 омгийн эсрэгтөрөгч, хамгаалан-тогтворжуулагч орчин агуулна.

04 Гадаад байдал, хэлбэр: Цайвар шаргал, шаргал өнгийн хуурай нунтаг

05 Зориулалт: Тахал өвчнийг үүсгэгч вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай

06 Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс: Шувуу (тахиа, тагтаа, бөднө)-г нас, хүйс харгалзахгүйгээр вакцинжуулна. Шувууны аж ахуйд шувууг эхлээд 3 удаа вакцинжуулаад цаашдаа 4 сар тутамд тогтмол вакцинжуулна. Үүний тулд 10-14 хоногийн настай дэгдээхийд анхдагч тунг, 60 хоногийн настайд нь хоёрдогч тунг, 4-5 сарын настайд нь гуравдагч тунг олгоод улмаар 4 сар тутамд вакцинжуулна.

Амьтны төрөл	Олгох зам	Тун
Шувуу	Хамар, нүдэнд дусаах	1 тун буюу 0,05 мл
	Амаар олгох	2 тун буюу 0,1 мл

08 Олгох зам: Хамар, нүдэнд дусаах, ундны усанд уусгаж амаар олгоно.

09 Дархлааны үргэлжлэх хугацаа: Вакцинжуулснаас 10-14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь шувууг 4 сарын турш тахалаас сэргийлнэ.

10 Шингэлэлт: Вакциныг хамар, нүдэнд дусааж олгох тохиолдолд 1 тунг 0,05 мл 0,9%-ийн натрийн хлорид (физиологийн уусмал)-ын уусмалд, амаар олгох, эсвэл шүршиж олгох тохиолдолд 2 тунг 0,1 мл ундны усанд уусгаж шингэлнэ.


11 Аюулгүй чанар: Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.

12 Гаж нөлөө: Тэмдэглэгдээгүй

13 Хадгалалт, хүчинтэй хугацаа: Вакциныг -15°C-ээс нам температурт харанхуй, хуурай нөхцөлд хадгалвал үйлдвэрлэсэн өдрөөс хойш 24 сар хүртэл хүчинтэй.

14 Бүртгэлийн дугаар: QF-1350

15 Үйлдвэрлэгч: Sinopharm Yangzhou Vac Biological Engineering Co., Ltd



ШУВУУГ ЦЭЦЭГ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ АМЬД ВАКЦИН

01 **Олон улсын нэр:** Avian pox vaccine, Live (Qual-Adapted Strain)

02 **Тодорхойлолт:** Шувууг цэцэг өвчнөөс сэргийлэх амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч *Poxviridae* язгуурын *Carpoxvirus* төрөлд хамаарах ДНХ агуулсан, (CVCCAV1003) вирусн хоруу чанарыг сулруулсан, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгийг шугаман эсэд өсгөвөрлөж, тусгай найрлага бүхий тогтворжуулан-хамгаалах орчинтой зохих харьцаагаар хольж, лиофилизацийн аргаар хуурайшуулан бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.

03 **Найрлага:** Вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч вирусн хоруу чанарыг нь сулруулсан омог (Бөднө шувуунд дасгасан)-ийн эсрэгтөрөгч, хамгаалан-тогтворжуулагч орчноос бүрдэнэ. Вирусн агууламж нь 1 тунд $10^{3.0} \text{EID}_{50}$ -аас багагүй байна.

04 **Гадаад байдал, хэлбэр:** Цайвар шаргал, шаргал өнгийн хуурай нунтаг

05 **Зориулалт:** Цэцэг өвчний үүсгэгч вирусн халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай

06 **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Вакциныг шошгонд заасны дагуу шингэлж, цэцгийн вакцины зориулалтын оллогчийг ашиглаж вакцинжуулна. 20-30 хоногийн настай дэгдээхийд 1 тун, 30-аас дээш хоногийн настай дэгдээхийд 2 тун, 6-20 хоногийн настай дэгдээхийд ½ тун (1 тунг 1 дахин шингэлж)-аар тус тус олгоно. Дэгдээхийг вакцинжуулснаас 60 хоногийн дараа 1 тунгаар давтан вакцинжуулж болно.

07 **Олгох зам:** Далавчны дотор талын цусны судасгүй хэсгийн арьсан дор тарьж олгоно.

08 **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцины зохистой тунг олгосноос 10-14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь нас гүйцсэн шувуунд 5 сар, дэгдээхийд 2 сар үргэлжилнэ.

09 **Шингэлэх арга:** Вакцины 1 тунг 0,05 мл 0,9%-ийн натрийн хлорид (физиологийн уусмал)-ын уусмалаар шингэлнэ.

10 **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.

11 **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй

12 **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Вакциныг 2-8°C-д хадгалвал 12 сар, -15°C-ээс нам температурт харанхуй, хуурай нөхцөлд хадгалвал үйлдвэрлэсэн өдрөөс хойш 18 сар хүртэл хүчинтэй.

13 **Бүртгэлийн дугаар:** QF-1351

14 **Үйлдвэрлэгч:** Sinopharm Yangzhou Vac Biological Engineering Co., Ltd



ШУВУУГ ТАХАЛ, ХАЛДВАРТ БРОНХИТ, ШУВУУНЫ ХАНИАДААС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН (La Sota омог + M41 омог + НР омог)

01 Олон улсын нэр: Newcastle disease, Infectious bronchitis and Avian influenza (Subtype H19) vaccine, Inactivated

02 Тодорхойлолт: Шувууг тахал, халдварт бронхит, шувууны ханиадаас сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин нь эдгээр халдварт өвчнийг үүсгэгч вирусын дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудыг тахианы үр хөврөлт өндөгний амнион-аллантайс бүрхүүл болон шугаман эсэд өсгөвөрлөж, формальдегидээр идэвхгүйжүүлэн тосон адьюванттай зохих харьцаагаар хольж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.

03 Найрлага: Вакцин нь тахал өвчнийг үүсгэгч вирусын La Sota омгийн эсрэгтөрөгч, халдварт бронхит өвчнийг үүсгэгч вирусын M41 омгийн эсрэгтөрөгч, шувууны ханиадны H19 дэд хэвшлийн NP омгийн эсрэгтөрөгч агуулна.

04 Гадаад байдал, хэлбэр: Сүүн цагаан, цайвар шаргал өнгийн эмульсэн шингэн

05 Зориулалт: Тахал, халдварт бронхит, шувууны ханиадыг үүсгэгч вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай .

06 Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс: Тахианы умай орчмын арьсан дор болон булчинд тарьж хэрэглэнэ. 2 долоо хоногийн настай дэгдээхийд 0,2 мл, 2-4 долоо хоногийн настай дэгдээхийд 0,3 мл, 4 долоо хоногос дээш настай болон нас гүйцсэн залуу тахиад 0,5 мл тарина.

07 Олгох зам: Арьсан дор, булчинд тарьж олгоно.

08 Дархлааны үргэлжлэх хугацаа: Вакцинжуулснаас 10-14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь 4 долоо хоногийн настай дэгдээхийд 2 сар, 4 долоо хоногос дээш настай дэгдээхийд 3 сар, нас гүйцсэн тахиад 4 сар үргэлжилнэ.

09 Аюулгүй чанар: Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.

10 Гаж нөлөө: Тэмдэглэгдээгүй

11 Хадгалалт, хүчинтэй хугацаа: Вакциныг 2-8°C-ийн харанхуй хуурай нөхцөлд хадгалвал үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй. Хөлдөөж үл болно.

12 Бүртгэлийн дугаар: QF-1345

13 Үйлдвэрлэгч: Sinopharm Yangzhou Vaccine Biological Engineering Co., Ltd



ШУВУУГ ТАХАЛ, ХАЛДВАРТ БРОНХИТ, ШУВУУНЫ ХАНИАД, ХАЛДВАРТ БУРСАЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН (La Sota омг + M41 омг + SZ омг + rVP2 уураг)

- 01** **Олон улсын нэр:** Newcastle disease, Infectious bronchitis, Avian influenza (Subtype H19) and Infectious bursal disease vaccine, Inactivated
- 02** **Тодорхойлолт:** Тахал, халдварт бронхит, шувууны ханиад, халдварт бурсалаас сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин нь эдгээр халдварт өвчнийг үүсгэгч вирусын дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудыг тахианы үр хөврөлт өндөгний амнион-аллантай бүрхүүл болон шугаман эсэд өсгөвөрлөж, формальдегидээр идэвхгүйжүүлэн тосон адьюванттай зохих харьцаагаар хольж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- 03** **Найрлага:** Вакцин нь тахал өвчнийг үүсгэгч вирусын La Sota омгийн эсрэгтөрөгч, халдварт бронхит өвчнийг үүсгэгч вирусын M41 омгийн эсрэгтөрөгч, шувууны ханиадны H19 дэд хэвшлийн SZ омгийн эсрэгтөрөгч болон халдварт бурсал өвчнийг үүсгэгч вирусын рекомбинант rVP2 уураг агуулна. Идэвхгүйжүүлэлтийн өмнөх тахлын вирусын La Sota омгийн таныц 0.1 мл-т $\geq 4 \times 10^{8.0}$ EID₅₀, халдварт бронхитын вирусын M41 омгийн таныц 0.1 мл-т $\geq 4 \times 10^{6.0}$ EID₅₀, ханиадны H9 дэд хэвшлийн SZ омгийн таныц 0.1 мл-т $\geq 4 \times 10^{8.0}$ EID₅₀ тус тус байна. Халдварт бурсал өвчний вирусын рекомбинант VP2 уургийн идэвхийг агар диффузийн аргаар тодорхойлоход $\geq 1: 64$ байна.
- 04** **Гадаад байдал, хэлбэр:** Сүүн цагаан, цайвар шаргал өнгийн эмульсэн шингэн
- 05** **Зориулалт:** Вакцин нь тахал, халдварт бронхит, шувууны ханиад, халдварт бурсал өвчнийг үүсгэгч вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай .
- 06** **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** 7-14 хоногийн настай дэгдээхийд 0,3 мл, 14 хоногоос дээш настай шувуунд 0,5 мл тунгаар тарина.
- 07** **Олгох зам:** Арьсан дор, булчинд тарьж олгоно.
- 08** **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцинжуулснаас 10-14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь 7-14 хоногийн настай дэгдээхийд 4 сар, 14 хоногоос дээш настай шувуунд 6 сар үргэлжилнэ.
- 09** **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.
- 10** **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй
- 11** **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Вакциныг 2-8°C-ийн харанхуй хуурай нөхцөлд хадгалвал үйлдвэрлэсэн өдрөөс хойш 18 сар хүртэл хүчинтэй. Хөлдөөж үл болно.
- 12** **Бүртгэлийн дугаар:** QF-1349
- 13** **Үйлдвэрлэгч:** Sinopharm Yangzhou Vac Biological Engineering Co., Ltd



ШУВУУГ ТАХАЛ, ШУВУУНЫ ХАНИАДААС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ХАМ ВАКЦИН (La Sota омог + F омог)

01 Олон улсын нэр: Combined Newcastle disease and Avian influenza (Subtype H19) vaccine, Inactivated

02 Тодорхойлолт: Тахал, шувууны ханиадаас сэргийлэх идэвхгүйжүүлсэн хам вакцин нь эдгээр халдварт өвчнийг үүсгэгч вирусын дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудыг тахианы үр хөврөлт өндөгний амнион-аллантайс бүрхүүл болон шугаман эсэд өсгөвөрлөж, формальдегидээр идэвхгүйжүүлэн тосон адьюванттай зохих харьцаагаар хольж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.

03 Найрлага: Вакцин нь тахал өвчнийг үүсгэгч вирусын La Sota омгийн эсрэгтөрөгч, шувууны ханиадны H19 дэд хэвшлийн F омгийн эсрэгтөрөгч болон тосон адьювант, идэвхгүйжүүлэгч агуулна.

04 Гадаад байдал, хэлбэр: Сүүн цагаан, цайвар шаргал өнгийн эмульсэн шингэн

05 Зориулалт: Тахал болон шувууны ханиадыг үүсгэгч H9 дэд хэвшлийн вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.

06 Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс: Эхийн эсрэгбиом үүссэн болон эхийн эсрэгбиом үүсээгүй (1 хоногтой дэгдээхийд тахал өвчний эхийн эсрэгбиом, шувууны ханиадны H9 дэд хэвшлийн) дэгдээхийг дараах тунгаар тус тус вакцинжуулна. Үүнд:

- Эсрэгбиомийн таньц 1:32-аас ихгүй дэгдээхийд эхлээд 7-14 хоноийн настайд нь 0,2 мл;
- Эсрэгбиомийн таньц 1:32-аас дээш дэгдээхийд 14 хоногийн настайд нь 0,5 мл;
- Тахианы өндөглөлт эхлэхээс 2-3 долоо хоногийн өмнө 0,5 мл тунгаар тарина.

07 Олгох зам: Вакциныг тахианы умайн хүзүү хэсгийн булчинд эсвэл арьсан дор тарих замаар олгоно.

08 Дархлааны үргэлжлэх хугацаа: Вакцинжуулснаас 21 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлааны үргэлжлэх хугацаа нь вакцинжуулахаас өмнөх эсрэгбиомийн таньцаас хамаарч харилцан адилгүй байна. Үүнд:

- Эсрэгбиомийн таньц 1:32-аас ихгүй дэгдээхийд 2 сар;
- Эсрэгбиомийн таньц 1:32-аас дээш дэгдээхийд 5 сар;
- Нас гүйцсэн өндөглөгч тахиад 6 сар байна.

09 Аюулгүй чанар: Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.

11 Гаж нөлөө: Тэмдэглэгдээгүй

11 Хадгалалт, хүчинтэй хугацаа: Вакциныг 2-8°C-ийн харанхуй хуурай байранд хадгалвал үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй. Хөлдөөж үл болно.

12 Бүртгэлийн дугаар: QF-1348

13 Үйлдвэрлэгч: Sinopharm Yangzhou Vaccine Biological Engineering Co., Ltd



ШУВУУГ ТАХАЛ, ХАЛДВАРТ БРОНХИТ, ӨНДӨГЛӨЛТ БУУРАХ ХАМ ШИНЖ, ШУВУУНЫ ХАНИАДААС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ХАМ ВАКЦИН (La Sota омог + M41 омог + AV127 омог + NJO2)

01 **Олон улсын нэр:** Newcastle disease, Infectious bronchitis, Egg drop syndrome and Avian influenza (Subtype H19) Combined vaccine, Inactivated

02 **Тодорхойлолт:** Тахал, халдварт бронхит, өндөглөлт буурах хам шинж, шувууны ханиадаас сэргийлэх идэвхгүйжүүлсэн хам вакцин нь эдгээр халдварт өвчнийг үүсгэгч вирусын дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудыг тахианы үр хөврөлт өндөгний амнион-аллантайс бүрхүүл болон шугаман эсэд есгөөрлөж, формальдегидээр идэвхгүйжүүлэн тосон адьюванттай зохих харьцаагаар хольж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.

03 **Найрлага:** Вакцин нь тахал өвчнийг үүсгэгч вирусын La Sota омгийн эсрэгтөрөгч, халдварт бронхит өвчнийг үүсгэгч вирусын M41 омгийн эсрэгтөрөгч, өндөглөлт буурах хам шинж өвчнийг үүсгэгч вирусын AV127 омгийн эсрэгтөрөгч, шувууны ханиадны H19 дэд хэвшлийн NJO2 омгийн эсрэгтөрөгч агуулна. Идэвхгүйжүүлэлтийн өмнөх тахлын вирусын La Sota омгийн таньц $\geq 4 \times 10^{0.8} \text{EID}_{50}/0,1 \text{мл}$, халдварт бронхитын вирусын M41 омгийн таньц $\geq 4 \times 10^{6.7} \text{EID}_{50}/0,1 \text{мл}$, өндөглөлт буурах хам шинж өвчний вирусын AV127 омгийн гемаглютинацийн таньц $\geq 1:1024$, ханиадны вирусын H9 дэд хэвшлийн NJO2 омгийн таньц $\geq 4 \times 10^{8.0} \text{EID}_{50}/0,1 \text{мл}$ тус тус байна.

04 **Гадаад байдал, хэлбэр:** Сүүн цагаан, цайвар шаргал өнгийн эмульсэн шингэн

05 **Зориулалт:** Вакцин нь тахал, халдварт бронхит, өндөглөлт буурах хам шинж болон шувууны ханиадны үүсгэгч вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.

06 **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Өндөглөгч тахиаг өндөг дарахаас 2-4 долоо хоногийн өмнө вакцинжуулна. Хүзүүний ар талын арьсан дор 0,5 мл тунгаар тарина.

07 **Олгох зам:** Арьсан дор тарьж олгоно.

08 **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцинжуулснаас 10-14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь 5 сар үргэлжилнэ.

09 **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.

10 **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй

11 **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Вакциныг 2-8°C-ийн харанхуй хуурай нөхцөлд хадгалвал үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй. Хөлдөөж үл болно.

12 **Бүртгэлийн дугаар:** QF-1344

13 **Үйлдвэрлэгч:** Sinopharm Yangzhou Vaccine Biological Engineering Co., Ltd





976-7049-2132



Info@biocombinat.mn



www.biocombinat.mn



БИОКОМБИНАТ ТӨХХК
Монгол улс Улаанбаатар хот-17140,
Хан-Уул дүүрэг, 12-р хороо